
# Хууль, эрх зүйн мэдээлэл #9

**2026 оны 11-р сар**

## Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орлоо

### Хураангуй



2026 оны 7 дугаар сарын 3-ны өдөр Монгол Улсын их хурлаас Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг баталсантай холбогдуулан нийт 91 хуульд нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд бид үүнээс бизнесийн байгууллагуудад ач холбогдол бүхий өөрчлөлтүүдийн талаар цуврал “Хууль, эрх зүйн мэдээлэл” бэлтгэн хүргэж буй билээ. Та өмнөх дугаартай *уг холбоосоор* орж танилцах боломжтой.

Энэ удаагийн дугаараар Хөрөнгө оруулалтын тухай хууль (2013) (**“ХОтХ”**)-д орсон дараах нэмэлт өөрчлөлтүүдийг онцоллоо.

1. Хөрөнгө оруулалтын тухай хуульд тусгагдсан шинэ ойлголт, нэр томъёоны талаар
2. Хөрөнгө оруулагчийн гомдол, маргааныг шийдвэрлэх зохицуулалт
3. Татварын хувь, хэмжээг тогтворжуулах гэрчилгээнд холбогдох нэмэлт зохицуулалт

### 1 Хуульд тусгагдсан шинэ нэр томьёоны тодорхойлолт

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлд тус хуульд хамаарах нэр томьёоны тодорхойлолт тусгагдсан байх ба Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг баталсантай холбогдуулан 2 шинэ ойлголт, нэр томьёог тодорхойлжээ. Үүнд:

**Хөрөнгө оруулагчийн гомдол** → Төрийн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоотойгоор хөрөнгө оруулагчаас эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар гаргасан хүсэлт

**Хөрөнгө оруулалтын маргаан** → Хөрөнгө оруулалт, эсхүл хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбогдуулан хөрөнгө оруулагч болон төрийн байгууллага хооронд үүссэн маргааныг

Иймхүү тодорхойлсоны дагуу хөрөнгө оруулагч нь өөрийн хууль ёсны ашиг сонирхол нь төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хөндөгдсөн тохиолдолд Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага буюу Эдийн засаг, хөгжлийн яамд гаргаж болох юм.

### 2 Хөрөнгө оруулагчийн гомдол, маргаан шийдвэрлэх

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг баталсантай холбоотойгоор ХОтХ-д хөрөнгө оруулагчийн гомдол болон хөрөнгө оруулалтын маргаан гэх шинэ тодорхойлолт болон үүнтэй холбоотой зохицуулалтуудыг шинээр зохицуулсан байх ба Хөрөнгө оруулагчийн гомдол, маргааныг шийдвэрлэх тухай шинэ бүлэг мөн нэмэгджээ.

**Хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэх**

Өмнө хэсэгт дурдсанчлан, хөрөнгө оруулагч нь хуульд заасны дагуу төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн талаарх асуудлаар гомдол гаргах эрхтэй ба тус гомдлыг Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага 30 хоногийн дотор хянан үзэж шийдвэрлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд 30 хоногоор сунгаж болох талаар заажээ.

Харин Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах тохиолдолд гомдлыг хүлээн авахаас татгалзаж, буцааж болно. Үүнд:

- Үндсэн хуулийн цэц, шүүх, мөрдөн шалгах ажиллагааны шатанд байгаа болон хянан шийдвэрлэгдсэн эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэрэг, маргааны талаарх гомдол;
- Дотоодын, эсхүл гадаадын арбитр, эсхүл гадаад улсын шүүхийн шатанд шийдвэрлэгдэж байгаа болон хянан шийдвэрлэгдсэн маргаантай холбоотой гомдол;
- Тагнуул, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, төрийн гадаад бодлогыг шууд хэрэгжүүлэхтэй холбоотой гомдол;
- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын хянан шалгаж байгаа хүний эрхийн зөрчлийн талаарх гомдол;
- Татварын маргаан таслах зөвлөлөөр хянагдвал зохих татварын акттай холбоотой гомдол.

**Хөрөнгө оруулалтын маргаан:** Хөрөнгө оруулагч болон төрийн байгууллага хооронд үүссэн маргааныг хөрөнгө оруулалтын гэрээний дагуу шийдвэрлэх ба хэрэв хөрөнгө оруулалтын гэрээгээр зохицуулаагүй, эсхүл гэрээ байхгүй тохиолдолд талууд хэлэлцээний, эсхүл эвлэрүүлэн зуучлах замаар маргааныг шийдвэрлэх байна.

Хэрэв талууд маргааныг эвлэрүүлэн зуучлах замаар **6 сарын дотор** шийдвэрлэж чадаагүй бол талуудын харилцан тохиролцсон олон улсын, эсхүл үндэсний арбитраар шийдвэрлүүлж болох юм.

Хөрөнгө оруулалтын маргаанд холбогдох асуудлыг хуулиар шүүхийн онцгой харьяалалд хамааруулсан бол маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## 3 Тогтворжуулах гэрчилгээтэй холбогдох зохицуулалтын өөрчлөлт

**Тогтворжуулах гэрчилгээ** гэж шалгуур хангасан хөрөнгө оруулагч этгээдэд ХОтХ-д заасан албан татвар, төлбөрийн хувь, хэмжээг тогтворжуулах зорилгоор эрх бүхий байгууллагаас олгох гэрчилгээг хэлнэ.

Хөрөнгө оруулагч хуулийн этгээдийн Монгол Улсад хэрэгжүүлэх төсөл нь доор дурдсан шалгуурыг бүрэн хангасан тохиолдолд тогтворжуулах гэрчилгээ олгоно:

- Хөрөнгө оруулалтын нийт хэмжээ нь доор заасан хэмжээнд хүрэх
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэсэн байх
- Тогтвортой ажлын байр бий болгох;
- Дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх

| № | Хөрөнгө оруулалтын хэмжээ /төгрөг/ | | Гэрчилгээний хугацаа /жил/ |
|---|---|---|---|
| | Улаанбаатар хот | Бусад | |
| 1 | 20-50 тэрбум | 10-50 тэрбум | 10 |
| 2 | 50 тэрбум 1 төгрөг-100 тэрбум | | 15 |
| 3 | 100 тэрбум 1 төгрөгөөс дээш | | 20 |

Нэмэлт өөрчлөлтөөс өмнө тогтворжуулах гэрчилгээг үйл ажиллагааны салбараас шалтгаалан нутаг дэвсгэрийн 5 бүс тус бүрт ялгаатай хугацаагаар олгодог байсан. Харин одоо нутаг дэвсгэрийн 2 үндсэн бүсэд хөрөнгө оруулах хөрөнгийн хэмжээгээр тогтворжуулах гэрчилгээг олгохоор болжээ.

## Холбоо барих:

**Абдулхамид Муминов**
Партнер
Татвар, Хуулийн үйлчилгээ
abdulkhamid.m.muminov@pwc.com

**Батзулын Амарбат**
Менежер
Татвар, Хуулийн үйлчилгээ
amarbat.batzul@pwc.com

**Рагчаахүүгийн Мөнхжаргал**
Ахлах менежер
Татвар, Хуулийн үйлчилгээ
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

**Энхбатын Ариун-Ундрал**
Хуулийн зөвлөх
Татвар, Хуулийн үйлчилгээ
ariun-undral.enkhbat@pwc.com

**Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН**

Сентрал Тауэр, 6 давхар
601 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
www.pwc.com/mn

www.pwc.com/mn
Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хуулийн зөвлөгөө биш юм. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээлэлд үндэслэн хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлага хүлээхгүй болно.
© 2026 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү мэдээлэлд дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ийг илэрхийлнэ.